



ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ӨГӨГДЛИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БОДЛОГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хэрэгжилт

2023-09-26



ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

Зорилт: Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах.

- Хувь хүний нууцын тухай хуулиар хүний эрүүл мэнд, захидал харилцаа, хөрөнгө, гэр бүлийн нууцтай холбоотой мэдээллийг нууцад хамааруулсныг хуулийн төсөлд өргөжүүлж **хувь хүнийг тодорхойлох боломжтой** бусад мэдээллийн талаар ангилан зааж өгсөн.
- **Мэдээллийн эзэн** хэн болохыг тодруулж, түүний эдлэх эрх буюу хуульд зааснаас бусад тохиолдолд мэдээллийг мэдээллийн эзний **зөвшөөрөлгүйгээр** цуглуулж, боловсруулж, ашиглахыг хориглох, эрх нь зөрчигдсөн тохиолдолд гомдол гаргах зохицуулалтыг оруулсан.
- Хүний хувийн **мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа этгээдийн** мэдээллийн эзний өмнө хариуцлага хүлээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор түүний хүлээх үүргийн талаар нарийвчлан тусгаж өгсөн.
- Хуульд зааснаас бусад тохиолдолд **хүний эмзэг мэдээлэл буюу биометрик болон генетик** мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахыг хориглохтой холбоотой онцлог зохицуулалтыг оруулж өгсөн.
- **Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн** төхөөрөмж байршуулах талаар буюу ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө, караоке, зочид буудлын өрөө, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх хэвтүүлэн эмчлэх өрөө зэрэг хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд дүрс бичлэгийн төхөөрөмж байршуулахыг хориглохоор тусгасан.



НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Зорилт: Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон иргэний мэдээлэл авах эрхийн эрх зүйн орчныг сайжруулах.

- Төрд цугларсан мэдээллийг боловсруулж **нээлттэй өгөгдөл** болгон, түүнийг иргэд, хуулийн этгээд ашиглах боломжийг бүрдүүлэх
- Нийтийн мэдээлэлд суурилан төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хүндрэл, зардал багатайгаар, шуурхай хүргэх, төрийн байгууллагууд хоорондоо цахимаар мэдээлэл солилцох орчин, боломжийг бүрдүүлэх **нийтийн мэдээллийн дэд бүтцийн** талаарх эрх зүйн зохицуулалтыг бий болгох.
- Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй 5 чиглэлийн 68 төрлийн багц **мэдээлэл нээлттэй байна**
- Нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг **хувь хүн, хуулийн этгээдээс шаардахгүй** байхыг
- Цахим баримт бичгийн баталгаажилт, энэ нь цаасан баримт бичигтэй адил хүчинтэй байх, **нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх** асуудлыг шийдвэрлэх.



НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Нийтийн мэдээлэл (нээлттэй, хязгаарлалттай, хаалттай мэдээлэл)



Мэдээллийн эзэн

Мэдээлэл хариуцагч

Мэдээллийн эзний зөвшөөрөл,
мэдэгдэл хүргүүлэх

Суурь болон төрөлжсөн
мэдээллийн сан

Үндсэн болон дэмжих систем,
мэдээлэл хариуцагчийн систем

Нийтийн мэдээллийн дэд бүтэц

Хуулийг хэрэгжүүлэх төрийн байгууллагын
тогтолцоо, бүрэн эрх, чиг үүрэг



МЭДЭЭЛЭЛ

- 4.1.4."мэдээлэл ашиглах" гэж мэдээллийг цуглуулах, боловсруулахаас бусад хэлбэрээр үйл ажиллагаандаа хэрэглэх, дамжуулах болон мэдээлэлтэй танилцахыг;
- 4.1.5."мэдээлэл боловсруулах" гэж мэдээллийг ангилах, хадгалах, дүн шинжилгээ хийх, өөрчлөх, устгах, сэргээх үйл ажиллагаа, тэдгээрийн нийлбэрийг;
- 4.1.6."мэдээлэл цуглуулах" гэж мэдээллийг олж авах, бүрдүүлэх, бүртгэх үйл ажиллагааг;
- 4.1.8."нийтийн мэдээлэл" гэж нийтийн мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд цуглуулсан, боловсруулсан, ашиглаж байгаа өгөгдлийн бүрдлийг;

ӨГӨГДӨЛ

- 12.1.Хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр, тэдгээрийн эрэлт, хэрэгцээг харгалзан эдийн засаг, бизнесийг дэмжих, судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй, хязгаарлалттай болон хаалттай мэдээллийн хүн, хуулийн этгээд, төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон боловсруулж, нээлттэй өгөгдөл болгож болно.


МЕТА ДАТА

- "мета-өгөгдөл" гэж өгөгдлийн бүтэц, формат, чанар, агуулга, мэдээлэл хариуцагч, эх сурвалж, боловсруулсан арга зүйг тайлбарласан өгөгдлийг ойлгоно.

НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ

1. 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн Засгийн газрын 201 дүгээр тогтоол
"Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"
2. 2022 оны 09 дугаар сарын 19-ны өдрийн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан А/268 А/48 тушаал
"Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам"
3. 2022 оны 09 дугаар сарын 22-ны өдрийн Засгийн газрын 352 дүгээр тогтоол
"Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"

НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ



НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ

Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам /2022.05.18 дугаар-200/

Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам /2022.05.18 дугаар-200/

Нээлттэй өгөгдлийн жагсаалт /2022.06.15 дугаар-232/


Нээлттэй өгөгдлийн төлбөр тооцох аргачлал /2022.05.18 дугаар-202/

Төрөлжсөн бүртгэлийн жагсаалт батлах тухай /2023.05.03 дугаар-164/

НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ

57 байгууллага

826 БҮРДЭЛ



НЭГ. МЭДЭЭЛЭЛ, СОЛИЛЦООНЫ СИСТЕМ

- ✓ АЛБАН ЁСНЫ ЭХ СУРВАЛЖААС МЭДЭЭЛЛИЙГ ДАВХЦУУЛАХГҮЙ
- ✓ МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГАА
- ✓ МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ, ТОГТОЛЦОО

632 Сервис

128 төрийн байгууллага

321 хувийн байгууллага

40 сая сард дунджаар

А.
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА



Б.
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
СОЛИЛЦООНЫ СИСТЕМ




Г.
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА



Д.
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

ХОЁР.CLOUD ШИЛЖҮҮЛЭХ


CLOUD ШИЙДЭЛ



- ✓ Хүний нөөц
- ✓ Програм хангамж
- ✓ Зориулалтын орчин
- ✓ Аюулгүй байдал
- ✓ Сүлжээний урсгал
- ✓ Тасалдалгүй байдал

ГУРАВ. Big data

ТӨРИЙН НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САН ҮҮСГЭХ



Өгөгдлийн талаар баримтлах чиглэл




Мета дата платформ



Хувийн мэдээлэл нууцлах

“Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам”





БАЯРЛАЛАА